

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.05.05

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн ИТХ-ын ээлжит XVIII хуралдааныг 04 дүгээр сарын 29-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнгийн тухай

2.Сэлэнгэ аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

3.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийн ойгоос мод шилжүүлэн суулгах модны үнэлгээг тогтоосон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Журам, үнэлгээ батлах тухай” 75 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болгох тухай

4.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг тус тус хэлэлцсэн.

Дээрх асуудлаас аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Сэлэнгэ аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэж, аймгийн ИТХ-ын 75-р тогтоолыг хүчингүй болгож, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмын төслийг буцаасан.

Аймгийн ИТХ-ын **Тэргүүлэгчид** 2 удаа хуралдаж, 12 асуудал хэлэлцэн 11 тогтоолыг баталлаа. Үүнд:

1.Жендерийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц үр дүнг “Хангалттай” гэж үнэллээ.

2.Аймгийн ИТХ-ын ээлжит XVIII хуралдааныг зарлалаа.

3.Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй спорт заалны барилгыг тоног төхөөрөмжийн хамт тус тосгоны Спорт цогцолборт, Баруунбүрэн сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Спорт заалны барилгыг тус сумын Спорт цогцолборт, аймгийн Боловсрол соёл урлагийн газрын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тоног төхөөрөмжийг зарим сумын Соёлын төв, цэцэрлэг, ЕБС-иудад шилжүүллээ.

4.Номгон тосгоны Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, Мандал сумын Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, Цант-Орхон ХХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл нь ашиглалтын хугацаа дуусч, сэргээн засварлах боломжгүй болсон тул дээрх тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоов.

5.Хөдөө аж ахуйн газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Мандал сумын иргэн Доржпаламын Арвинг “Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

6.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийн төрийн одон медалиар шагнуулахаар уламжлав. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 6, Цэргийн гавьяаны улаан тугийн

одонгоор 1, Алтан гадас одонгоор 21, Хөдөлмөрийн хүндэт медалиар 10 иргэнийг тус тус шагнуулахаар уламжиллаа.

7.Зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлж 6-аас доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өгсөн хүмүүжүүлсэн Сэлэнгэ аймгийн харьяат 38 эхийг Алдарт эхийн I одонгоор, 4-5 хүүхэд төрүүлж 4-өөс доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өгсөн хүмүүжүүлсэн 346 эхийг Алдарт эхийн II одонгоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

8.Монгол Улсын Гавьяат багш, нэрт сэхээтэн Гочоогийн Даваагийн Монгол улсын боловсролын салбарт тасралтгүй идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хөдөө аж ахуйн боловсон хүчин бэлтгэх үйлсэд оруулсан гаргасан амжилт, хөдөлмөрч чанарыг нь залуу хойч үедээ үлгэр дуурайлал болгон мөнхжүүлэх зорилгоор Мандал сумын Ерөнхий боловсролын II сургуулийг Монгол улсын Гавьяат багш Гочоогийн Даваагийн нэрэмжит болголоо.

9.Шаамар сумын Дулаанхаан тогсоны ЕБС-ийн үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг 2020 оны 10 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрөв.

10. 2019-2020 оны хичээлийн жилд БСШУСЯ, Боловсрол телевиз хамтран улсын хэмжээнд зохион байгуулсан “Би багш” уралдаант, зорилтот нэвтрүүлэгт амжилттай оролцож тэргүүлсэн амжилтыг нь үнэлж Мандал сумын ЕБ-ын III сургуулийн бага ангийн багш Цэрмаагийн Аюушийг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнав.

11.Сэлэнгэ аймгийн ИТХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулахад аймгийн төвийн сумын баг тус бүрийг 1, Ерөө, Сайхан сумдыг тус бүр 2, Мандал сумыг 5, бусад сум тус бүрийг 1 тойрог болгон нийт 30 тойрог байгуулж, аймгийн ИТХ-ын нийт төлөөлөгчдийн тоог 37 байхаар тогтоолоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг аймгийн ИТХ-ын ээлжит XVIII хурлаар энэ сарын 29-ны өдөр хэлэлцүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оны байдлаар 93,1 хувьтай, 2016-2020 оны өсөн нэмэгдсэн дүнгээр 90,4 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнаж, “Хангалттай” үнэлгээ авлаа.

Энэ сарын 13-нд аймгийн Засаг дарга аймгийн төв Сүхбаатар суманд ажиллалаа. Ажиллах үеэрээ 7 дугаар багийн гурилын шар 5 давхрын өмнө баригдахаар эхлүүлээд орхигдон хуучин байрны орчин, барилгын дэргэдэх автомашины грашийг чөлөөлөн хүүхдийн тоглоомын талбай байгуулах зорилгоор эзэмшигч байгууллагад хүсэлт явуулан шийдвэрлүүлэх, орчныг цэгцлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагын удирдлагуудад чиглэл өгсөн. Мөн тухайн орчин дахь өнгө үзэмжгүй хашаа, нүхэн жорлон бүхий газруудын хууль ёсны эзэмшигч эзэдтэй уулзаж, модон хашаа, нүхэн жорлонг буулгах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Сүхбаатар сумын Засаг даргад үүрэг болголоо. Мөн Сүхбаатар сумын 8 дугаар багийн иргэдийн хүсэлтийн дагуу аймгийн зүгээс холбогдох газарт хандсаны үр дүнд УБТЗ-ын хойд чиглэл дэх 25 дугаар зөрлөгийн гарамыг 4-р сарын 30-ны өдрөөс нээлээ.

Аймгийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх “Ногоон паспорт-Ногоон төгөл аян”-ы хүрээнд “Өрх бүр хашаандаа 2 мод тарья” уриалгыг дэвшүүлж, мэдээлэл сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4-р сарын 14-ний өдрөөс томилсон. Үүний дагуу сумдын сонгуулийн хороог 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, СЕХ-оос өгсөн чиглэл, цагалбарын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх ажлын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран аймгийн төвийн үйлчилгээний нэгдсэн төв болон Алтанбулаг, Мандал, Сайхан, Цагааннуур, Жавхлант, Орхонтуул, Шаамар, Хүдэр сумдад операторийн горимоор үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх бэлтгэлийг хангаж, 4-р сарын 30-аас 5-р сарын 1-ний

өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн, дээрх сумдын ЗДТГ-ын дарга, төрийн захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад хамруулж, техник, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Төрийн албаны зөвлөлөөс энэ сарын 17-ны өдөр "Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" төрийн албаны зөвлөлийн 141 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн албаны тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтын талаарх арга зүйн зөвлөгөөг өгөх онлайн сургалт хийгдсэн бөгөөд сургалтанд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, гишүүд хамрагдсан. Чиглэлийн дагуу аймгийн хэмжээний төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг нэгтгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн гишүүдэд цахим сургалт хийлээ. Сургалтад аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга, аймгийн ерөнхий Прокурор, ХЭЗХ-ийн дарга, аймгийн Цагдаагийн газрын төлөөллүүд оролцло. Сургалтаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2019 оны зөвлөмжийн мөрөөр хийсэн хяналт, шалгалтын дүн болон аймгуудын батлагдсан төсөв түүний зарцуулалт, авлига, ашиг сонирхолтой холбоотой гомдол, мэдээлэл, хориглолт, хязгаарлалт зөрчиж байгаа тухай мэдээллийг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ болон ТББ, ИНБ-ын үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг зөвлөлөө.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 331 дүгээр тогтоолоор Хүдэр суманд Эрэн хайх аврах салбар шинээр байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд эхний ээлжинд томилогдсон алба хаагчдыг үүрэг гүйцэтгэх ажлын байранд хүргэн өгч байрны засвар үйлчилгээний ажлыг эхлүүлээд байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар гарсан тогтоол, шийдвэр, Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу аймгийн Онцгой комисс 5 удаа хуралдаж үүссэн нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөн ажиллаж байна. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд аймгаас орох гарах хөдөлгөөнийг түр хугацаанд хязгаарлах арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн хэмжээнд энэ сарын эхээр тусгаарлалтад 26 иргэн байснаас өнөөдрийн байдлаар 10 иргэн, гэрийн ажиглалтад 52 иргэн байна.

ОХУ-аас 405 ачаа тээврийн том оврын автомашин нэвтэрсэн. Уг машинуудыг ариутгал халдваргүйжүүлэлтэд хамруулан цагдаагийн байгууллагын хяналт дор Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудын гүний хяналтад шилжүүлж ажиллалаа.

Хуурайшилтын зэрэг нэмэгдэж аюултай түвшинд хүрсэнтэй холбогдуулан ой хээрт үйл ажиллагаа явуулахыг хориглох, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэг ажилуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гарч эрсдэл өндөр сумддад мэргэжлийн байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгүүд 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн үүрэг гүйцэтгэж эхэлсэн.

Тайлант хугацаанд аймгийн Онцгой байдлын газарт аюулт үзэгдэл, ослын 12 удаагийн дуудлага ирсэн. Үүнд:

-Гэр орон сууцны гал түймрийн 7

-Усны ослын 1

-Ой хээрийн түймрийн 4 дуудлага тус тус ирсэн байна.

Дуудлагын дагуу газрын албан хаагчид үүрэг гүйцэтгэж, ахуйн болон ой хээрийн түймрийг бүрэн унтраасан. Усны ослын дагуу эрлийн ажиллагааг зохион байгуулж байна.

Гол нуурын мөсөнд цөмрөх, эд хөрөнгө амь насаа алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж ярилцлага, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шар усны

үер, хүчтэй цасан болон шороон шуургаанаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжүүдийг sea.nema.gov.mn, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын page хуудас, аймгийн ЗДТГ-ын page хуудас, Сэлэнгэ зар зэрэг олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд түгээн ажилласан.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар

Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалт 116, төлөвлөгөөт бус 17, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 264 аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хийж, 844 зөрчил, дутагдлыг илрүүлэн 256 зөрчлийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах тухай 104 албан шаардлагыг хүргүүлж, ажиллалаа. Зөрчил дутагдлын 62 хувийг арилгуулж, 6 газрын үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл хугацаагаар түр зогсоож, 19 аж ахуйн нэгж, иргэнд 15.550.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулалт 75 хувьтай байна.

Мөн зөвлөн туслах үйлчилгээг 33 обектод, тандалт судалгааг 22 обектод, 38 удаа хяналт шинжилгээ хийсэн байна.

Ус хангамжийн ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг “Урсгал ус” ХХК, “Цант орхон” ХХК, “Гавшгай ус ХХК”-ийн үйл ажиллагаанд хийж, 4 төрлийн 18 дээж авч МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулахад шинжилгээний дүнгээр 11 дээж стандартын шаардлага хангахгүй гарч, 7 дээж стандартын шаардлага хангасан үзүүлэлттэй гарсан. Илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр улсын байцаагчдын хамтарсан 3 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Ариутгал халдваргүйтгэлд хэрэглэж байгаа жавилсин, жавелионд итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулахад шинжилгээний дүнгээр жавелионы хлорын идэвхи 34.33-42,58 хувь, жавилсины хлорын идэвхи 18.85-36.74 хувьтай, уусмал нь 0.09 хувьтай гарсан байна.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Сүхбаатар, Шаамар, Мандал сумын сумын 13 аж ахуйн нэгжийн 7 хүнсний дэлгүүр, 5 хүнсний мухлаг 1 цайны газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгосон байна.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Сүхбаатар сумын 4-р багт байрлалтай “Сэлэнгэ” талхан цехийн 2 төрлийн талх, Сайхан сумын “Хөтөл Дээжис” бялуун цехийн “Сүүн кремт” бялууг МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт гаргасан. Сайхан сумын “Ханк” ХХК-ийн үйлдвэрлэж буй 3 нэрийн 9 бүтээгдэхүүний хаяг шошгыг МУ-ын “MNS 6648:2016 Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтонд тавих шаардлага” стандартын шаардлагад нийцүүлэн хийх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Стандартын салбар сан:

Салбар сангаас 7 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 6 нэрийн 8 стандартын борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

“Цемент Шохой” ХХК болон МХГ-ын Сорилтын лабораторийн 23 электрон жин, 14 ш туухайнд шалгалт тохируулга хийж, гэрчилгээ олгосон. Мөн мал эмнэлэгийн 3 шилэн хэмжүүрт шалгалт тохируулга хийсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр Баянгол, Мандал, Сайхан сумын “Дашваанжил” ХХК-ий АХЦС-ын 8 түгээгүүр Сүхбаатар сумын 2 ШТС-ын 8 шатахуун түгээгүүрт ээлжит баталгаажуулалт хийсэн.

Цахилгааны хэмжлийн төрлөөр айл өрх, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 фазын 29ш цахилгааны тоолуурыг шалган баталгаажуулсан.

Эмнэлэг болон иргэн, аж ахуй нэгжийн 22 ш термометр, 23 ш цусны даралтын аппарат шалган баталгаажуулсан. Хөтөл сум дундын эмнэлэгийн хэмжих хэрэгслийг ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар: /3 дугаар сарын гүйцэтгэлээр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		27,616,010.9	25,646,500.6	92.9
1.1	Орон нутгийн төсвийн орлого	6,237,259.2	5,857,908.8	93.9
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,853,470.3	4,252,625.3	87.6
	Сумдын төсвийн орлого	1,383,788.9	1,605,283.5	116.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1,952,741.0	1,952,741.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	15,544,482.9	15,544,482.9	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	1,232,063.9	389,126.7	31.6
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,600,526.5	1,600,526.5	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	301,714.7	301,714.7	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	747,222.7	234,703.5	
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		27,616,010.9	19,833,645.0	71.8
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	27,616,010.9	19,833,645.0	71.8
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	4,804,975.1	3,495,463.8	72.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	241,098.9	25,567.6	-
	Сумдын сум хөгжүүлэх сан	-	-	-
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	4,621,819.1	2,320,201.0	50.2
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,005,088.8	189,857.6	18.9
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1,120,571.6	291,020.3	26.0
	Халамжийн сан	69,757.5	14,400.0	20.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	2,224,049.8	1,658,826.9	74.6
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	202,351.4	166,096.2	82.1
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	17,636,925.5	13,702,562.3	77.7
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	311,192.3	289,850.4	93.1
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		21,758,727.8	20,039,828.2
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,982,181.0	4,106,218.6	82.4
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	35,335.5	35,335.5	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	35,335.5	35,335.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,196,728.4	353,791.2	29.6
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1,158,123.4	315,186.2	27.2
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	38,605.0	38,605.0	
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	15,235,988.2	15,235,988.2	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	308,494.7	308,494.7	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	15,544,482.9	15,544,482.9	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	8,311,751.7	8,311,751.7	100.0

	- Хүүхдийн цэцэрлэг	4,869,305.8	4,869,305.8	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	2,016,147.2	2,016,147.2	100.0
	- Газрын кадастрын байгууллага	179,242.1	179,242.1	100.0
	- Хүүхдийн байгууллага	168,036.1	168,036.1	100.0
4. Тусгай сангуудын зарлага		747,222.7	234,703.5	31.4
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	747,222.7	234,703.5	31.4

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2019 03- сар	2020 03- сар	<u>2020- 03</u> <u>2019-03</u> /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 200	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 500	104.2
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	8 500	130.8
	Үхрийн мах /кг/	8 300	9 500	114.5
	Адууны мах /кг/	7000	7 500	107.1
	Ямааны мах /кг/	6 000	7 500	125.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 800	1 800	100.0
	Сүү / савласан, л/	2 600	3000	115.4
	Тараг /задгай, л/	2 000	2 000	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	4 200	110.5
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 000	100.0
	Лууван /кг/	1200	1 200	100.0
	Манжин /кг/	1200	1500	125.0
	Байцаа /кг/	1500	1200	80.0
	Сонгино /кг/	1500	1800	120.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 200	120.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 680	102.1
	Бензин А - 92	1 725	1 780	103.2
	Дизелийн түлш	2 275	2 470	108.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 3 сард 77 холбогдогчтой 388.8 сая төгрөгийн хохиролтой, 174 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 47-оор буюу 21.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 30.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 7.7 хувиар өссөн байна. 5624 зөрчил илрүүлсэн нь 1434 зөрчлөөр буюу 20.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 04 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 356, лавлагаа 4, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 126, лавлагаа 8 олгосон.

Иргэний бүртгэлийн чиглэлээр дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

-Төрсний бүртгэл – 194 /эрэгтэй-92, эмэгтэй-102/

-Гэрлэлтийн бүртгэл – 35

-Гэрлэлт цуцалсны бүртгэл – 10

-Үрчлэлт - 7

-Эцэг тогтоолт – 5

-Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 7

-Нас баралт – 57

-Нийт олгосон иргэний үнэмлэх – 406

-Шинээр олгосон иргэний үнэмлэх – 102

-Дахин олгосон иргэний үнэмлэх – 68

-Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 236

-Гадаад паспорт олголт – 22 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын талаар

Боловсролын хүрээлэнгийн захирлын 2020 оны 72 тоот албан бичгийн дагуу сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан теле хичээлийн хүртээмж, үр дүнгийн талаарх онлайн судалгаанд цэцэрлэгийн бүх бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багш нарыг хамруулах, 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэн суралцах хүүхдийн бэлтгэлийг хангаж, гэр бүл эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн, сургуульд бэлтгэх зорилгоор гаргасан “Та хүүхдэдээ сургуульд орохын өмнө хэрхэн туслах вэ?” гарын авлагыг цэцэрлэгээр дамжуулан хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2020 онд ерөнхий шалгалт өгөх шалгуулагчдын бүртгэлийг хуваарийн дагуу хийн хичээл сонголтын тулгалтыг хийж дуусган 12-р анги төгсөж буй 34 сургуулийн 892 сурагч, өмнөх оны 98 шалгуулагч, нийт 990 шалгуулагч ерөнхий шалгалтад бүртгүүлээд байна. Энэ онд 12 дугаар анги төгсөгчид болон ЭЕШ-д бэлтгэгчдэд зориулсан онлайн сорилгыг зохион байгуулсан.

1, 5, 10 дахь жилдээ ажилласан багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтад хамрагдаж байгаа багш нарын онлайн даалгаврын гүйцэтгэл, хандалтыг нэмэгдүүлэх, регистрийн болон БСМС-д бүртгэлгүй байгаа зөрчлүүдийг арилгуулан арга хэмжээ авсан.

“Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төслийн хүрээнд хийгдэж буй “Сургуулийн орчин” гарын авлага, “Эко сургууль”-ийн гадаад, дотоод орчинд хийгдсэн туршлагаас тусгах зорилгоор 35 сургуулийн 1, 1 туршлагыг тайлбар, зургийн хамт Байгаль орчны мэдээлэл, сургалтын төвд [/ecoschool.mn@gmail.com/](mailto:ecoschool.mn@gmail.com) цахимаар хүргүүлсэн.

Цэцэрлэгийн хүүхэд, эцэг эхчүүд, сургагч багшид зориулсан “Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй”, өсвөр насны хүүхдэд зориулсан “Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй” сэдэвт сургалтын онлайн хичээлийг цэцэрлэг, сургуулийн эмч, анги удирдсан багш нарт цахимаар хүргүүлж, сурталчлан хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч ажиллаж байна.

2.Эрүүл мэндийн талаар:

Ковид-19 өвчний халдвар гарсан улс орнуудаас ОХУ-аар дамжин ирсэн иргэдийг түр тусгаарлах байранд хүлээн авч ажиллаж байна. Ажиглалтын 4 байранд эмч, эмнэлгийн албан хаагчид 2 ээлжээр буюу аймгийн нэгдсэн эмнэлгийн тусгаарлах байранд 19 эмнэлгийн мэргэжилтэн, ажиглалтын байр, дамжуулан өнгөрүүлэх түр байруудад 37 эмнэлгийн мэргэжилтэн, нийт 56 эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэг өдрийн байдлаар давхардсан тоогоор 752 иргэн үйлчлүүлдэг бөгөөд иргэд цаг авах гэж бөөгнөрөл үүсгэж байгааг харгалзан аймгийн Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, бөөгнөрөлийг бууруулах зорилгоор 7766-0103 дугаарын утасыг 4-р сарын 09-өөс эхлэн ажиллуулж, иргэдийгн эмнэлэгт очиж, үзлэгийн цаг авахгүйгээр хүссэн газраасаа захиалах боломжийг бүрдүүллээ.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2020 оны 4-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 545 байсан бол 163 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн62 ажлын байранд 47 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 82 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 579 болсон байна. Нийгмийн халамжийн сангаас эхний 4 сарын байдлаар 34194 иргэнд 5,741,604.7 мянган төгрөгийг олгоод байна.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан иргэдийн ажлын байртай газар дээр нь очиж танилцаж ажиллалаа.

Нийтийг хамарсан ажлаар Сүхбаатар сумын 8 багийн нутаг дэвсгэрт орон нутгийн бүртгэлтэй ажилгүй 90 иргэнийг хамруулж, хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Мөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Хушаат, Шаамар, Мандал, Баянгол, Орхон, Орхонтуул, Сайхан, Алтанбулаг, Сант, Баруунбүрэн зэрэг сумдад үлийн цагаан оготно устгах ажлыг зохион байгуулж байна.

Тайлант сард нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгож ажиллалаа. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2331 иргэнд 1,679,984.4 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1615 иргэнд 537,594.3 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1566 иргэнд 328,733.4 мянган төгрөг
- Онцгой тохиолдлын амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 16 иргэнд 19,200.0 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 2060 иргэнд 121,063.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 232 иргэнд 28,686.7 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 1376 эхэд 123,122.1 мянган төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 73 иргэнд 33,540.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8681 иргэнд 1,129,000.0 мянган төгрөг
- Насны хишиг 4791иргэнд 374,420.0 төгрөг
- Цалинтай ээж хөтөлбөр 5528 иргэнд 1,002,550.3 мянган төгрөг
- Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 208 иргэнд 84,466.2 мянган төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмжинд 6 иргэнд 12,000.0 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 5711 иргэд 267,244.3 мянган төгрөг

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шилжин ирсэн 7 дуудлагыг хяналтандаа авч, хамтарсан баг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилбал: Сэтгэл

санааны хүчирхийлэл 4, үл хайхрах хүчирхийлэл 1, бие махбодын хүчирхийлэл 2 тус тус байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны А/52 дугаар тушаалаар “Хүүхэд эрхэм хэрэглэгч-2020” аяныг удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллалаа. Аяны хүрээнд Шинэ төрлийн корона вирус буюу COVID-19 цар тахлын хорио цээрийн дэглэм тогтоосонтой уялдуулан хүүхдүүд болон тэдний гэр бүлд чиглэсэн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх уриалгыг Сэлэнгэ хүүхэд фейсбүүк хуудсанд байршуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дархлааг дэмжих зорилгоор байнгын асаргаатай 166 хүүхдэд “зөв аарц”, гар ариутгагч, санитолын дэмжлэг үзүүлсэн.

Идэвхтэй хөдөлгөөн уриан дор “Гэр бүлээрээ дуурайж бүжиглэцгээе цахим бүжгийн уралдааныг бага насны хүүхэд, сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бүжиглэх сонирхолтой хүүхэд багачуудыг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор 2-5 нас, 6-11 насны ангиллаар зохион байгуулж нийт 248 хүүхэд оролцсон. “Эх дэлхийдээ эрүүл оршихуй” 2050 онд илгээх цахим захидлын уралдааныг 12-14 насны буюу 6-9 ангийн 58 сурагч, 15-18 насны буюу 10-12 дугаар ангийн 67 сурагч, нийт 125 сурагч оролцон, өөрсдийн оюун ухаан, мэдлэг чадвараараа өрсөлдсөн.

Дэлхийн гэр бүлийн өдрийг угтаж “Удам судраа мэдэж, угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг өрнүүллээ. Аяныг Монгол хүний төрөл удмын холбоог илэрхийлдэг угийн бичгийн ач холбогдол, хүн бүр удам угсаагаа мэдэж цэвэр ариунаар хадгалан хамгаалж, харилцаа холбоогоо тогтоох, өвөг дээдсийнхээ гэр бүлийн уламжлалт соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор угийн бичгээ хөтөлдөг, өөрөөсөө дээш 9 үеэ мэддэг, “Угийн бичиг хөтөлдөг үлгэрчилсэн загвар”-т тулгуурлан угийн зураглал гаргасан, ахмад, залуу гэр бүл гэсэн 2 ангиллаар I, II, III байрыг шалгаруулж, гэр бүлийн фото зураг авахуулах эрхийн бичиг, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулж аянд нийт 15 ахмад, 9 залуу гэр бүл оролцсон.

Сэтгэл зүйн албадан сургалтыг 14 хоногт 1 удаа зохион байгуулж байгаа бөгөөд энэ сард эрүүлжүүлэх байранд шүүхийн шийдвэрээр баривчлагдсан 9 иргэнд “Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх нь”, “Архины хор нөлөө ба түүний хор уршиг” 2 удаагийн сургалтыг хийлээ.

5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөөр эхний 4 сард 10,6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 4 дүгээр сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 9,7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 91,1 хувийн биелэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17250 тэтгэвэр авагчдад 19,614,454 мянган төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 1728 хүнд 905,211 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 207 хүнд 287,244 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 107 хүнд 316,079 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс энэ сард нийт 4 удаа хуралдаж, 511 хүн орсоноос 405 хүн актыг сунгаж, 66 хүн шинээр тогтоож, 40 хүний актыг цуцалсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг байдлаар 477 лавлагааг иргэд, аж ахуй нэгжид цахим болон цаасан хэлбэрээр гарган түргэн шуурхай үйлчлсэн.

Тав.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд

1.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний талаар

“Атар IV” аяны хэрэгжилтийг эрчимжүүлэх, хаврын тариалалтын бэлтгэлийг хангаж технологийг шуурхай зохион байгуулах зорилгоор 7 хоног бүр зохион байгуулсан ажил, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг сумаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Хаврын тариалалтанд ашиглах 344 зүтгэх хүчний трактор, 113 үрлүүр, 143 борной, 189 сийрүүлэгч, 87 сэндэчлэгч, 71 анжис ажиллах төлөвтэй байна. Өнөөдрийн байдлаар Ерөө, Цагааннуур, Хушаат, Орхонтуул, Шаамар, Баянгол, Мандал, Сайхан, Цагааннуур, Хушаат, Баянгол, Ерөө сумдын зарим аж ахуйн нэгжүүд техник засвар үйлчилгээндээ гарч, засвар үйлчилгээний ажил 80 хувьтай, чийг хаалтын ажил 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын “Газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор олгож буй зээлэнд хамруулах судалгааг аймгийн хэмжээнд 17 сумын 380 аж ахуйн нэгж, 2500 иргэний хамруулахаар саналыг хүргүүлж ажиллалаа.

Энэ онд аймгийн хэмжээнд 788735 толгой хээлтэгч мал төллөхөөс 526189 толгой мал төллөөд байна. Үүнээс ингэ 58, гүү-9192, Үхэр-40456, эм хонь 267592, эм ямаа-208891 төллөж мал төллөлт 66.5 хувьтай, төл бойжилт 99,7 хувьтай байна. Төлийн хорогдол 2061, том малын зүй бус хорогдол 1347 байна.

2020 онд мал сүрэгт хийгдэх зохиомол хээлтүүлгийн захиалга, богд малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтанд хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгааг сумдаас авч нэгтгэн малын удмын сангийн үндэсний төвд хүргүүллээ.

Бэлчээрт хөнөөл учруулж буй хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг Алтанбулаг, Мандал, Баянгол, Сант, Сайхан, Орхон, Орхонтуул, Хушаат сумдын 60000 га талбайд энгийн механик аргаар хийж гүйцэтгэхээр сумдын хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил хайгч иргэдийг оролцуулан гэрээ байгуулаад байна.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг ажиллуулах талаар МЭЕГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт мал эмнэлгийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээлэл, бүртгэлмэдээллийгоруулахталаар заавар, зөвлөгөө өгч мал эмнэлгийн нэгдсэн системээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Энэ сард 17 сумын 888 иргэнд цахим гэрчилгээгээр адуу 468, үхэр 1110, тэмээ 10, хонь 2223, ямаа 1149 тэмээ 8, гахай 47, тахиа 40 бүгд 5045 толгой мал амьтан, мах 35260кг, цувдаа 782кг, толгой 87ш, шийр 34ш, бүгд мах махан бүтээгдэхүүн 36163кг, сүү 70681л, ааруул 2456кг, тараг 5 кл, нийт сүү сүүн бүтээгдэхүүн 73137кг, арьс шир 103ш, ноос 10 кг, ноолуур 450 кг нийт түүхий эд 563 ш/кг тус тус мал эмнэлгийн нэгдсэн системээр мал эмнэлгийн гэрчилгээ олгон баталгаажууллаа.

Өөр аймаг сумруу шилжин явсан адуу 166, үхэр 400, хонь 389, ямаа 70 тахиа 40 нийт 1065 толгой мал амьтан шилжин явсан. Үүнээс: Отроор адуу 27, үхэр 13 бүгд 40 толгой, Үзэсгэлэн худалдаа, уралдаан тэмцээнд адуу 18 толгой, Үржилээр адуу 121, үхэр 387, хонь 389, ямаа 70, тахиа 400 бүгд 1007 толгой мал амьтан тус тус шилжин явсан. Өөр аймаг сумаас шилжин ирсэн адуу 184, үхэр 291, хонь 346, ямаа 127, гахай 13 нийт 961 толгой мал амьтан шилжин ирсэн. Үүнээс:Отроор адуу 125, үхэр 235, хонь 83, ямаа 103, гахай 13 бүгд 559 толгой, Үзэсгэлэн уралдаанд адуу 9, үхэр 1, хонь 3, ямаа 24, бүгд 37 толгой, Үржилээр адуу 50, үхэр 55, хонь 260, бүгд 365 толгой мал амьтан тус тус шилжин ирсэн дүн мэдээтэй байна.

Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтэрсэнтэй холбогдуулан Баруунбүрэн сумын “Бүрэн сүрэг”, “Батцэнгүүн” МЭҮН-үүд мини хэвлэгч 2, Түшиг сумын “Мөнх зэлтэр” МЭҮН компьютер 1, принтер 1, “Эх жишиг” МЭҮН компьютер 1-ийг тус тус авч ашиглаж байна.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй хүнсний зах, худалдааны төв, нийтийн хоолны газрын хүнсэнд хэрэглэгдэж байгаа мал, амьтны гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, өндөг, цагаан идээ, дайвар бүтээгдэхүүнд мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээг олгосон.

Үүнд: Адууны 360 кг махны 4 дээж, 4560 кг үхрийн махны 38 дээж, 1260 кг хонины махны 60, 260 кг ямааны махны 13 дээж, 50 кг дайвар бүтээгдэхүүний 1, 540 кг сүү, цагаан идээний 26 дээж, нийт 141 дээжинд шинжилгээ хийж, 6440 кг маханд гэрчилгээ олгосон.

Шинэ короновирусийн халдвар, шувууны ханиад дэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 17 сумын 45 МЭҮН-үүд гахайн байрны 7520 м2, шувууны байрны 4200 м2, эрчимжсэн аж ахуйн 13000 м2, нийтийн эзэмшлийн зам талбайн 23500 м2, нийт 48220 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа.

2. Байгаль орчны талаар

Сумдын Засаг дарга нарт 2021 онд ойгоос бэлтгэх модны санал ирүүлэх тухай албан тоотын төслийг боловсруулан ажиллаж байна. Аймгийн ОБГ-тай хамтран түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг батлуулсан. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд сумдын байгаль хамгаалагч бүрт бүс нутгийн хэмжээнд түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж хүргүүлэх зорилгоор 40 000 төгрөгний шатахууны зардлыг олгохоор төлөвлөсөн. Мөн түймрээс урьдчилан сэргийлэх зэрлэг амьтнаас амь нас, эд хөрөнгөө хамгаалах санамж, сурталчилгааны материал 2000 ширхэгийг хэвлүүлсэн.

Түшиг сумын “Хоёр тулга”, “Усан зам хоршоо”, Ерөө сумын “Бэх Бөх” ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн ойн менежмент төлөвлөгөөг газрын даргаар батлуулан сумдад хүргүүлсэн.

Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахаар 12 төсөл ирснээс 5 төсөлд нөхцөл болзолтой хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан. 7 төсөл нь материал дутуу тул буцаасан.

-Байгаль орчны мэдээллийн санд нийт 26 үнэлгээний дүгнэлтийг оруулсан.

“Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ” аяны хүрээнд нийт 6 сумдаас тайлан мэдээ ирсэн. Covid 19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2 удаагийн бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулсан. COVID 19 халдварт өвчин гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын 2020 оны “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 03 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны ханш нээх өдөр буюу 04 дүгээр сарын 03-04-ны өдрийн хооронд хяналт шалгалтын ажлыг аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар Шаамар, Сүхбаатар сумдын Засаг даргын тамгын газруудтай хамтран ээж мод орчимд зохион байгуулсан.

3. Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар

Аймгийн хэмжээнд 2020 онд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 158 тендерийг зарлахаас 4-р сарын 29-ний байдлаар 100 ажлын тендер зарлагдаж, 42 төсөл арга хэмжээний гэрээг байгуулж, 28 төсөл арга хэмжээ үнэлгээний шатанд, 32 арга хэмжээ нь материалыг хүлээн авах шатандаа явагдаж байна.

4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн Сүхбаатар сум дахь “Дашваанжил” ХХК-ий АЦСтанц, “Гэрэлт хөшөө, цогцолбор”-ын зам талбайн тохижилт, Ерөө сумын 110 кВ-ын ЦДАШ-ын трассын өөрчлөлт, Ерөө сумаас Бугант тосгон хүртэлх шилэн кабел татах ажлын зургийг хянан баталгаажуулж, Шаамар сум Дулаанхаан тосгоны ахуйн үйлчилгээний барилга, Сайхан сумын 400 хүний суудалтай спорт ордоны төсөл арга хэмжээнд архитектур төлөвлөлтийн даалгавар гаргаж өглөө.

Тайлант сард Сүхбаатар төмөр замын боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилга угсралтын ажил, Улаанзагалмайн хорооны байрны засварын ажил, Алтанбулаг сумын спорт заалны барилга, Бугант тосгоны соёл, спортын

цогцолборын барилга, Мандал сумын төвийн доторх авто зам, тохижилт, Зүүнхараа политехник коллежийн өргөтгөл, засварын ажил, мөн сумын 5.3 км бохир усны хоолойны шугамын ажил, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Мандал сум хүртэлх авто замтай холбох хатуу хучилттай авто замын ажил, Дулаанхан тосгоны Ахмадын байрны засварын ажил, Түшиг суманд баригдаж буй 60 ортой дотуур байрны барилгын ажил болон Сүхбаатар сумын иргэн Б.Уламбаярын ахуйн хэрэглээний гадна цахилгаан хангамжийн ажилд ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон.

Техник хяналтын чиглэлээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд баригдаж буй “120-н ортой сургуулийн барилгын өргөтгөл” –ийн барилга, Түшиг суманд баригдаж буй “60-н ортой дотуур байр”-ны барилга угсралтын ажил, Хүдэр суманд баригдаж буй “10-н ортой эрүүл мэндийн төв”-ийн барилга угсралтын ажил, Мандал сумын Түнхэл тосгонд баригдаж буй “10 ортой эрүүл мэндийн төв”-ийн барилга угсралтын ажил, Мандал сумын 5.3 км бохирын шугам угсрах ажил, Мандал сумын төвийн дотор зам тавих, тохижилтийн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багт 3 нэгж талбар, Баянхаан 4-р баг 2 нэгж талбар, Салхит 3-р багт 2 нэгж талбарыг хаягжуулалтын журмын дагуу дугаарлан, Хонгор морьт 1-р баг багт 3 нэгж талбарт нэр өгч аймгийн мэдээллийн санд бүртгэж, Сүхбаатар суманд гарсан зөрчил маргааны дагуу 5 нэгж талбар дээр хяналтын хэмжилт хийж, нийтийн эзэмшил газрыг зөвшөөрөлгүй ашигласан өргөдөл гомдлын дагуу 1 иргэнд мэдэгдэх хуудас өгч ажилласан. Сэлэнгэ аймаг Мандал сумын 192.168.49.10 IP-тай SEA1 корсыг хэвийн үйл ажиллагааг хангаж хэмжилтийн алдааг засж ажилласан. Инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг шинэчлэн 192.168.10.37 серверт 5 сумын газар доорх шугам сүлжээний мэдээллийг баяжуулан ажилласан.Сэлэнгэ аймаг Алтанбулаг сумын 3-р багт байрлах 7 га газарт зураг үйлдэн Сэлэнгэ аймгийн ЗДТГазарт хүлээлгэн өгсөн.Том масштабын байр зүйн зургийг Монгол Улсын стандартад хөрвүүлэх ажлын хүрээнд Цагааннуур, Зүүнбүрэн сумын дэвсгэр зургийг MNS 6702:2017 хөрвүүлж ажилласан.

Зургаа.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Сум, орон нутгийн түвшинд төрийн ажил үйлчилгээ хэвийн явагдаж байна. Мал төллөлт, газар тариалангийн ажлын явцын мэдээллийг цаг тухайд нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажиллаж байна.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж буй Улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, зочид буудал зэрэг байгууллагуудын ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, гар ариутгах нөхцөл бүрдүүлэх, үйлчлэгч болон үйлчлүүлэгчид хувийн ариун цэврийг сахих, амны хаалт зүүж хэвших, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, шаардлага тавих, эцэг эхчүүд бага насны хүүхдийг гадуур дагуулж явах, үйлчлүүлэх, үйлчлэхийг хориглох, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаа, худалдан борлуулах цагийн хязгаарлалт, нийгмийн хэв журмыг хангах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хяналт тавин ажиллаж байна.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.БОЛОРЗУЛ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.ЭНХМАА